

Golomt Capital®

# Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.04.11

*Дотоодын зах зээл  
Олон улсын зах зээл*

## ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 4 сарын 11

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	2,970.93	1.615%	4.267%	4.255%

**Товч дүгнэлт:**

Өнгөрсөн 7 хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 1.71 хувиар чангарлаа. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангахаар Төв банк интервенцийг нэмэгдүүлж байгаа ч эрэлт өндөр байгаагаас ам.долларын ханш төгрөгийн эсрэг чангарсаар байна.

**Монголбанкны дуудлага худалдаа:**

Өнгөрсөн 7 хоногт Монголбанк банкнуудын 153 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг нийлүүлсэн байна. Харин банкнууд своп болон форварт арилжааны санал ирүүлээгүй байна.

**Ханшид нөлөөлөхүйц үйл явдал, суурь үзүүлэлтүүд:**

УИХ-ын 2022.04.08 өдрийн 48 тоот захирамжаар Олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон бусад хууль, тогтоолын төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах зэрэг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.

Тус ажлын хэсгийн ням гарагийн хуралдаанаар УИХ-ын дарга Г.Занданшатар УИХ-ын харьяа байгууллагуудын удирдлага хотод 570, 200 маркийн машин унахгүй бөгөөд хэмнэлтийг өөрсдөөсөө эхлэнэ хэмээлээ.

Мөн өмнөх төсвийн тодотголоор 5.6 тэрбумаар танасан бол дахин 10-аас багагүй хувиар танахаас өөр аргагүй хэмээжээ. Урсгал зардлын таналт нь валютын гарах урсгалыг багасгаж ханшийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөх юм.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 4 сарын 11

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	99.98	0.18%	1.68%	9.53%
EURUSD	1.0877	-0.84%	-0.28%	-8.66%
USDCNY	6.3717	0.13%	0.51%	-2.64%
USDRUB	-9.43	-9.43%	-33.41%	-1.67%
USDJPY	124.86	1.72%	6.49%	8.52%
AUDUSD	0.7436	-1.39%	2.02%	-2.43%


## DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг бага зэргийн чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын Холбооны нөөцийн сангийн хурлын тэмдэглэл гарсан бөгөөд инфляцын түвшин хэт гаарвал шаардлагатай арга хэмжээг авч Холбооны нөөцийн сан 5 сарын Нээлттэй захын хурлаар бодлогын хүүг 0.5 нэгжээр өсгөж болзошгүй талаар дурдсан байсан. Мөн ХНС-ийн балансыг 5 сараас эхлэн бууруулах ингэхдээ сард 95 тэрбум ам.доллараар бууруулах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн. Энэ нь долларын ханшийг бусад валютуудын эсрэг чангархад хангалттай түлхэц болохуйц мэдээлэл байлаа.
- Энэ долоо хоногт АНУ-ын 3 сарын ХҮИ-ийн мэдээлэл болон жижиглэн худалдааны мэдээлэл гарах төлөвтэй байгаа бөгөөд тус мэдээлэлтэй холбоотой ханшийн хөдөлгөөн өндөр байх төлөвтэй байна.

## График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 11/Apr/2022 - 3:18:03 GMT. Powered by TradingView.  
US Dollar Index, United States, NYSE:DXY, D



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.